



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/138/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Я.НАРАНБААТАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт
№ 48
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.


Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг..

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



T. Baygalmaa

Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>64,911,680.00</u>	<u>72,123,490.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	64,911,680.00	72,123,490.00
351	Түүхий эд материал	2,636,500.00	9,904,900.00
35130	Эм боох материал	2,636,500.00	9,904,900.00
354	Хангамжийн материал	62,275,180.00	62,218,590.00
35410	Бичиг хэргийн материал	1,172,380.00	3,508,180.00
35420	Аж ахуйн материал	60,252,800.00	58,710,410.00
35440	Түлш, шатах тослох материал	850,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,295,339,281.86</u>	<u>2,268,720,452.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,295,339,281.86	2,268,720,452.95
392	Биет хөрөнгө	2,238,479,281.86	2,210,660,452.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,163,041,796.00	2,163,041,796.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81,046,263.93)	(111,343,156.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,000,000.00	11,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,200,000.08)	(3,025,000.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,213,034.40	113,571,904.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,960,511.86)	(48,096,063.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,825,185.00	32,581,141.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,103,722.68)	(12,215,644.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,847,860.00	44,240,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,453,446.64)	(16,865,643.26)
39217	Ном	31,315,351.65	37,771,119.09
393	Биет бус хөрөнгө	56,860,000.00	58,060,000.00
39301	Програм хангамж	550,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	56,860,000.00	56,860,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,360,250,961.86</u>	<u>2,340,843,942.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,360,250,961.86</u>	<u>2,340,843,942.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,360,250,961.86	2,340,843,942.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	815,033,761.66	815,033,761.66
51101	Өмч: - төрийн	815,033,761.66	815,033,761.66
512	Хуримтлагдсан үр дүн	96,819,540.29	77,412,521.38
51210	Өмнөх үеийн үр дүн	96,819,540.29	96,819,540.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	(19,407,018.91)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,448,397,659.91	1,448,397,659.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,360,250,961.86</u>	<u>2,340,843,942.95</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,207,839,932.00	1,190,528,372.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,819,632.00	16,633,548.64
120	Нийтлэг татварын бус орлого	7,819,632.00	16,633,548.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,819,632.00	16,633,548.64
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	7,819,632.00	15,963,348.64
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		670,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,200,020,300.00	1,173,894,823.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,142,398,000.00	1,119,245,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,142,398,000.00	1,119,245,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,368,400.00	12,377,423.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,873,623.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,368,400.00	3,503,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,253,900.00	42,271,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,253,900.00	42,271,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,256,176,388.16	1,209,935,391.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,256,176,388.16	1,209,935,391.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,192,737,947.07	1,159,697,775.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	900,974,400.00	861,606,082.00
210101	Үндсэн цалин	629,752,000.00	625,069,587.28
210102	Нэмэгдэл	185,924,300.00	161,475,433.00
210104	Урамшуулал	85,298,100.00	75,061,061.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,542,099.91	112,194,995.18
210201	Тэтгэврийн даатгал	72,483,199.91	78,979,033.22
210202	Тэтгэмжийн даатгал	9,514,700.00	8,389,771.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,611,800.00	6,704,976.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,902,900.00	1,647,400.63
210205	Эрүүл мэндийн даатгал	19,029,500.00	16,473,813.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,322,699.00	43,107,907.00
210301	Гэрэл, цахилгаан	17,456,699.00	13,990,407.00
210302	Түлш, халаалт	23,528,000.00	28,398,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,338,000.00	719,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,848,478.00	14,992,763.64
210401	Бичиг хэрэг	1,257,100.00	1,895,023.64
210402	Тээвэр, шатахуун	2,898,380.00	3,240,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,471,800.00	1,085,200.00
210404	Ном, хэвлэл	7,482,700.00	391,200.00

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	810,900.00	896,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,774,700.00	2,592,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	6,152,898.00	4,891,590.00
2105	Нормативт зардал	44,465,500.00	64,956,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	556,800.00	3,292,900.00
210502	Хоол, хүнс	43,908,700.00	61,621,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	42,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,820,010.00	-
210604	Урсгал засвар	3,820,010.00	-
2107	Томилолт, зочны зардал	412,000.00	216,000.00
210702	Дотоод албан томилолт	412,000.00	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,715,800.00	9,779,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,065,800.00	9,779,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,636,960.16	52,844,427.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,651,600.00	5,022,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,985,360.16	47,822,077.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,438,441.09	50,237,615.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,693,170.00	26,252,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,536,370.00	24,702,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,888,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,581,201.00	13,593.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,581,201.00	13,593.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,164,070.09	23,971,622.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,164,070.09	23,971,622.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(48,336,456.16)</u>	<u>(19,407,018.91)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(48,336,456.16)</u>	<u>(19,407,018.91)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	815,033,761.66	1,448,397,659.91	96,819,540.29	2,360,250,961.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,407,018.91)	(19,407,018.91)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	815,033,761.66	1,448,397,659.91	77,412,521.38	2,340,843,942.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,200,020,300.00</u>	<u>1,173,894,823.64</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,200,020,300.00	1,173,894,823.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,142,398,000.00	1,119,245,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,142,398,000.00	1,119,245,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,368,400.00	12,377,423.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,873,623.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,368,400.00	3,503,800.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,253,900.00	42,271,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,253,900.00	42,271,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,189,280,400.00</u>	<u>1,168,654,923.64</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,189,280,400.00	1,168,654,923.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,125,897,928.91	1,118,417,307.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	900,974,400.00	861,606,082.00
210101	Үндсэн цалин	629,752,000.00	625,069,587.28
210102	Нэмэгдэл	185,924,300.00	161,475,433.00
210104	Урамшуулал	85,298,100.00	75,061,061.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,542,099.91	112,194,995.18
210201	Тэтгэврийн даатгал	72,483,199.91	78,979,033.22
210202	Тэтгэмжийн даатгал	9,514,700.00	8,389,771.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,611,800.00	6,704,976.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,902,900.00	1,647,400.63
210205	Эрүүл мэндийн даатгал	19,029,500.00	16,473,813.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,852,699.00	42,257,907.00
210301	Гэрэл, цахилгаан	17,456,699.00	13,990,407.00
210302	Түлш, халаалт	24,058,000.00	27,548,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,338,000.00	719,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,241,630.00	9,975,723.64
210401	Бичиг хэрэг	933,200.00	1,466,423.64
210402	Тээвэр, шатахуун	2,898,380.00	3,240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,471,900.00	1,085,200.00
210404	Ном, хэвлэл	7,632,050.00	391,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	809,400.00	896,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,496,700.00	2,896,700.00
2105	Нормативт зардал	46,589,100.00	74,599,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,892,700.00	10,506,300.00
210502	Хоол, хүнс	42,416,800.00	61,621,300.00

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,279,600.00	2,472,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,820,000.00	-
210604	Урсгал засвар	3,820,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	412,000.00	216,000.00
210702	Дотоод албан томилолт	412,000.00	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,666,300.00	9,779,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,016,300.00	9,779,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,799,700.00	7,787,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,799,700.00	7,787,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,382,471.09	50,237,615.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,637,200.00	26,252,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,480,400.00	24,702,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,888,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,581,201.00	13,593.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,581,201.00	13,593.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,164,070.09	23,971,622.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,164,070.09	23,971,622.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,739,900.00</u>	<u>5,239,900.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,739,900.00	5,239,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,739,900.00	5,239,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,739,900.00	5,239,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,739,900.00	5,239,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(10,739,900.00)</u>	<u>(5,239,900.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах өрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,161,517,400.00	1,137,532,184.18	(23,985,215.82)	97.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,161,517,400.00	1,137,532,184.18	(23,985,215.82)	97.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,128,297,700.00	1,111,279,784.18	(17,017,915.82)	98.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,478,500.00	861,606,082.00	(4,872,418.00)	99.44
210101	Үндсэн цалин	627,913,400.00	625,069,587.28	(2,843,812.72)	99.55
210102	Нэмэгдэл	162,135,000.00	161,475,433.00	(659,567.00)	99.59
210104	Урамшуулал	76,430,100.00	75,061,061.72	(1,369,038.28)	98.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,294,600.00	112,194,995.18	(4,099,604.82)	96.47
210201	Тэтгэврийн даатгал	83,752,200.00	78,979,033.22	(4,773,166.78)	94.30
210202	Тэтгэмжийн даатгал	8,135,600.00	8,389,771.37	254,171.37	103.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,508,500.00	6,704,976.22	196,476.22	103.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,627,100.00	1,647,400.63	20,300.63	101.25
210205	Эрүүл мэндийн даатгал	16,271,200.00	16,473,813.74	202,613.74	101.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,271,500.00	42,257,907.00	(13,593.00)	99.97
210301	Гэрэл, цахилгаан	15,047,400.00	13,990,407.00	(1,056,993.00)	92.98
210302	Түлш, халаалт	23,824,100.00	27,548,500.00	3,724,400.00	115.63
210303	Цэвэр, бохир ус	3,400,000.00	719,000.00	(2,681,000.00)	21.15
2104	Хангамж, бараа материалын зардал	9,102,100.00	9,102,100.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	1,087,800.00	1,087,800.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	3,240,000.00	3,240,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,085,200.00	1,085,200.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	391,200.00	391,200.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	401,200.00	401,200.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,896,700.00	2,896,700.00	-	100.00

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	81,832,000.00	74,599,700.00	(7,232,300.00)	91.16
210501	Өм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,506,300.00	10,506,300.00	-	100.00
210502	Хоол, хүнс	68,853,600.00	61,621,300.00	(7,232,300.00)	89.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,472,100.00	2,472,100.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	216,000.00	216,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	216,000.00	216,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,075,500.00	6,275,500.00	(800,000.00)	88.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,275,500.00	6,275,500.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	-	(800,000.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,027,500.00	5,027,500.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,027,500.00	5,027,500.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,219,700.00	26,252,400.00	(6,967,300.00)	79.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,219,700.00	26,252,400.00	(6,967,300.00)	79.03
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,669,700.00	24,702,400.00	(6,967,300.00)	78.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,550,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,161,517,400.00	1,137,532,184.18	(23,985,215.82)	97.94
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,119,245,900.00	1,095,274,277.18	(23,971,622.82)	97.86
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,119,245,900.00	1,095,274,277.18	(23,971,622.82)	97.86
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,271,500.00	42,257,907.00	(13,593.00)	99.97
132001	Орон нутгийн төсвөөс	42,271,500.00	42,257,907.00	(13,593.00)	99.97
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	-

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	77.00	77.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	31.00	31.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1.00	1.00	-	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1.00	1.00	-	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	1.00	1.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	77.00	77.00	-	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	46.00	46.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31.00	31.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	12,377,423.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	12,377,423.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	12,377,423.64
2104	Хангамж, бараа материалын зардал	-	873,623.64
210401	Бичиг хэрэг	-	378,623.64
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	495,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,503,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,503,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	8,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	12,377,423.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,377,423.64
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,873,623.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,503,800.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ж.Намуун нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сургалтын орчинд эрүүл аюулгүй байдлыг ханган сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалтын чанарт ахиц гаргах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургууль хүний хөгжлийн төв байх
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт тавьж ажилласан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Батлагдсан төсөв”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 11.6 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19.4 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна. Энэ нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	-	-
Бараа материал	64.9	72.1	7.2
Үндсэн хөрөнгө	2,295.3	2,268.7	(26.6)
Нийт хөрөнгө	2,360.3	2,340.8	(19.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,360.3	2,340.8	(19.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,360.3	2,340.8	(19.4)

3.5.1. Бараа материалын данс нь 64.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 139.1 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 0.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 132.5 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 72.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгө данс 2,295.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байгаа ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 5.2 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 16.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 19.6 сая төгрөгийн хөрөнгө акталж хассан байна. Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 163.3 сая төгрөг байснаас тайлант хугацааны элэгдэл 47.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, үндсэн хөрөнгийн акталсантай холбоотойгоор данснаас хассан элэгдэл 19.6 төгрөгөөр тус тус хасагдаж 2,268.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3. Цэвэр хөрөнгө өмчийн дүн 28.9 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,142.4	1,119.2	(23.2)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	50.3	42.3	(8.0)
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	7.4	12.4	5.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7.8	16.0	8.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	0.7	0.7
Үйл ажиллагааны орлого	1,207.8	1,190.5	(17.3)
Цалин, шимтгэлийн зардал	1,011.5	973.8	(37.7)
Бараа үйлчилгээний зардал	113.9	123.3	9.4
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1.7	9.8	8.1
Бараа үйлчилгээний бусад зардал	65.6	52.8	(12.8)
Урсгал шилжүүлэг	63.4	50.2	(13.2)
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-	-
Үйл ажиллагааны зардал	1,256.2	1,209.9	(46.2)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(48.3)	(19.4)	28.9

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого болон тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого өмнөх оноос 17.3 сая төгрөгөөр буурсан нь цар тахалтай холбоотойгоор сургуулийн үйл ажиллагаа зогсон, үдийн цай, байрны хоолны санхүүжилт буурсантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,161.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 1,161.5 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,161.5 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,161.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,137.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,137.5 сая төгрөг буюу 97.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 12.4 сая мянган төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2021 онд тус байгууллага нь “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой сургууль орчмын бүс, сургалтын байр анги танхимд 2 цаг тутам цэвэрлэгээ, 10 хоногт 2 удаа ариутгал хийж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 82 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 арга хэмжээнд зориулан нийт 27.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 27.0 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 100 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 147 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байх тул аудитаас зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 34.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, шилэн дансны хугацаа хоцроосны зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 34.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснөөс шилэн данстай холбоотой 1 албан шаардлага хэрэгжээгүй бусад зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг анхаарч үзэх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт 1.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 1.6 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 11.6 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: 58 хөрөнгийн кодтой 61 даралтат хөгжим болох 1.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл сөрөг байсан.

1.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн 13, 14-р зүйл болон УСНББОУС-ыг дагаж мөрдөх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль	2	1.6	0	0	0	0	1	0	1	1.6
Дүн		2	1.6	0	0	0	0	1	0	1	1.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн		0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн		2	1.6	0	0	0	0	1	0	1	1.6